

БАТЛАВ
 ЗАСАГ ДАРГА М.БАДАМ

2022 он 03 сар 28 өдөр

ХУДГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Байршил

№	Сумын нэр	Багийн нэр	Худаг гаргах газрын нэр	Санхүүжилтийн эх үүсвэр
1	"Бүрэгхангай"	"Дэрст"	"Ар тээл"	Малын тоо толгойн албан татвар
		"Цахт"	"Баруун даваа"	

2. Техникийн тодорхойлолт болон шаардлага

№	Үзүүлэлтүүд	Тендерт оролцогчдын санал
1. Цооног өрөмдөх, цооногийг тоноглох		
1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох	
1.2	Цооногын ашиглалтын ундарга 2м ³ -6м ³ ус өгөх хүчин чадалтай байна.	
1.3	Суултын яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.	
1.4	Шүүрийн яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.	
1.5	Ус өргөх яндангийн диаметр 25 мм-ээс материал нь төмөр ган яндан байна.	
1.6	Ус шүүх хайрга нь шигшсэн мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй мөхлөгийн хэмжээ 10-15 мм-ээс томгүй байна.	
1.7	Тунгаагуурын гүн 2м-ээс багагүй	
1.8	Худгийн шавалт хийж цэвэрлэх хугацаа 24 цагаас багагүй	
1.9	Усны чанарын сорилт авах шинжилгээ хийгдсэн байна.	
1.10	Худгийг түр хугацааны тагаар тоноглосон байна.	
1.11	Худгийн өрөмдлөгийн гүн 60м-ээс багагүй цооногтой байна.	
2. Худгийн байшин, усан сан, мал услах онгоц, талбай барих/малчид/		
2.1	<p>Худгийн байшингийн:</p> <ul style="list-style-type: none"> Хэмжээ /дотор талдаа цэвэр зай/ 3:3м, ханын өндөр шалнаас дээш 2м-ээс багагүй байна. Материал: тоосго, блок, модон Ханын зузаан: 38 см-ээс багагүй Худгийн байрны хаалга бат бөх төмрөөр хийгдсэн байна. Ханыг дотор талаас нь шавардаж цагаан өнгөөр будна. Худгийн дээр 30смх30см хэмжээтэй нээлхийг тохируулан хийнэ. Нээлхийг худаг засварлахад хэрэглэнэ. 	

	<ul style="list-style-type: none"> Худгийн цонх нь 40x50см хэмжээтэй, хамгаалалтын төмөр сараалжин хаалттай байна./ цонхны байрлал нь мал услах онгоцны чанх харалдаа байрлана/ 	
2.2	Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь 60мм диатетртэй, гаднах ханаас 2 м урттай гадагшилсан ган хоолойг цонхны дор гаргах	
2.3	Ундны ус авах хоолой нь 60мм диаметртэй ган хоолойг цонхны дор гаргах / ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгох/	
2.4	40 мм-ын диаметртэй цоорхойг генераторын утааг гадагшлуулах зорилгоор генераторын янданд яг тохируулан тохиромжтой байрлалд гаргана.	
2.5	Босоо суурьтай тоноглогдсон, гагнаж хийгдсэн, дотор талыг эвдрэлээс хамгаалсан 1,5м-ээс багагүй багтаамжтай ган усан сан, дээгүүрээ модон тагтай	
2.6	<p>Мал услах онгоцны:</p> <ul style="list-style-type: none"> Хэмжээ: 9 м-ээс багагүй урттай, 400мм-ийн голчтой хагас цилиндр Материал: ган яндан хоолой буюу цутгамал төмөр бетон Худгийн байшингаас 1-2 хэмийн налуутайгаар 2м-ийн зайд байрлуулна. Онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нээлхий гаргана Нээлхийг онгоцонд ус өгөх үед эрэгдэж хаадаг байхаар хийнэ. Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхахаар байрлуулж гаргана. Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засна. 	
2.7	<p>Мал услах талбай:</p> <ul style="list-style-type: none"> Хэмжээ: нийт уртын дагуу 2 талдаа 2м-ийн өргөнтэй, зузаан нь 10 см Материал: 150 маркаас доошгүй цемент хэрэглэнэ. Талбайг хийхдээ бетоныг төмөр тороор хүчитгэж өгнө. Услах талбай нь худгийн байшин болон мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуу байдалтай хийгдэх бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юүлэхэд тохиоромжтой байна. 	
2. Худгийн насос, бага оврын генератор,цахилгааны утас, хянах самбар /малчид/		
3.1	Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан Монгол улсын уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх. Үйлдвэрлэгчийн техникийн гэрчилгээ, зөвшөөрлийг хавсаргаж ирүүлнэ.	
3.2	Цахилгааны утас: 3 салаа, худагт ашиглах шаардлагыг хангасан, насосоос хянах самбар хүртэл үргэлжилсэн /залгаасгүй/, ус өргөх янданд 2м тутамд хавчиж /туузаар ороож болохгүй /тогтооно.	

3.3	Хянах самбар: Асаар, унтраах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчтэл буйг /улаан/ гэрлээ асаах индикатортой, насос ажиллуулах асаагууртай	
3.4	Бага оврын генератор: Бензинээр ажилладаг /ISO стандартын шаардлага хангасан/ Монгол улсын уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх. Үйлдвэрлэгчийн техникийн гэрчилгээ, зөвшөөрлийг хавсаргаж ирүүлнэ.	-
3. Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх		
4.1	Талбайг цэвэрлэх /өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал/	
4.2	Худаг, гүний насос, жижиг оврын генератор ажиллуулах, үйлчилгээ хийх талбайн сургалт хийх	
4.3	Худгийн паспортыг бүртгэх	

Бусад:

- 1 худгаас өдөрт 3200 мал услах хүчин чадалтай байх
- Тунгаагч нь шүүрний дотор байрлана.
- Усны ундаргын хэмжээ 2л/сек-ээс багагүй байна.
- 200 летрийн саваар хэдэн секундэд дүүргэхийг шалгах, зургаар баталгаажуулах
- Яндангийн диатетр 2,45 м-ээс багагүй байна.
- Цооногын голчийн диаметр 219 мм-ээс багагүй байна.
- Шүүрний урт 5м-ээс дээш байна
- Тунгаагуурын урт 2м-ээс багагүй
- Худгийн шүүр яндангийн диатетрийн хамгийн бага хэмжээ нь 168 мм-ээс багагүй байна.

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ц.МӨНХТУЛГА

БОЛОВСРУУЛСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН

В.БАТХУЯГ